**Арьсны эмчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын жишиг сорил**

**Сорил-1**

Сонгогдсон сорил

1. Нэг сонголттой тест ( Зөвхөн 1 хариулт зөв байх ) Энэ хэлбэрийн сорил нь A, B, C, D, E
гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )
   1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
   1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (B.)
   2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
   Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
   Бүх хариулт зөв бол (E.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
   Зөв, Зөв, Зөв (A.)
   Зөв, Зөв, Буруу (B.)
   Зөв, Буруу, Буруу (C.)
   Буруу, Зөв, Буруу (D.)
   Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Арьсны өнгөн хөрсний давхаргыг нэрлэнэ үү
A. Өргөст давхарга
B. Хөхлөг давхарга
C. Торлог давхарга
D. Өөхлөг давхарга

/2./ Хумс хэд хоногт бүрэн солигдох вэ?
A. 30 хоног
B. 50 хоног
C. 60 хоног
D. 90 хоног

/3./ 19. Халдварт нялаахай (моллюск) өвчний үед ямар тууралт гарах вэ?
A. Цэврүү
B. Толбо
C. Зангилаа
D. Гөвдрүү
E. Хайрс

/4./ Хуурай арьсны сөрөг үр дагавар юу вэ?
A. Толигор
B. Үрчийх хандлагатай
C. Бохирдохдоо амархан
D. Хөлрөмтгий

/5./ Ягаан үлдийн эх толбо биеийн аль хэсэгт гарах вэ?
A. Мөчдийн төгсгөлд
B. Нүүрээр
C. Салстад
D. Суганд
E. Их биеэр

/6./ Хамуу ямар хэрэгслээр халдварлахгүй вэ?
A. Цагаан хэрэглэл
B. Дотуур хувцас
C. Бээлий

D. Тоглоом
E. Аяга халбага

/7./ Арьс ямар үйл ажиллагаа гүйцэтгэдэггүй вэ?
A. Хамгаалах
B. Ялгаруулах
C. Дулаан зохицуулах
D. Мэдэрхүйн
E. Хортой нэгдэл үүсгэх

/8./ Дермад ямар ширхэг байдаггүй вэ?
A. Коллаген ширхэг
B. Уян ширхэг
C. Ретикуляр ширхэг
D. Гиалин ширхэг

/9./ Мөөгөнцөрт өвчнийг оношилоход дараах шинж голлоно
A. Мөнгөлөг хайрстай гөвдрүү
B. Идээт цэврүү
C. Бэлцрүү
D. Хайрстай дугуй хүрээтэй голомт

/10./ Нянгийн гаралтай намарс голлож хаана байрлах вэ?
A. Толгойн хуйх
B. Нүүр
C. Цээж
D. Хөлийн шилбээр

/11./ Цусархаг толбонд аль нь хамаарахгүй вэ?
A. Петехи
B. Пурпура
C. Экхимоз
D. Бэлцрүү

/12./ Түүхий өвчний онош тавихад
A. Товруу гарах
B. Бэлцрүү гарах
C. Үсэрхийлсэн идээт цэврүү
D. Хайрс

/13./ Арьсны хоёрдогч элемент
A. Цэврүүнцэр
B. Хайрс
C. Товруу
D. Толбо
E. Идээт цэврүү

/14./ Хамууны эмчилгээнд хэрэглэх эмийн бэлдмэл
A. 6% давсны хүчлийн уусмал
B. 5% салицилын хүчлийн тос
C. 20% бензил бензоат тос
D. Унна крем

/15./ Арьсны анхдагч элемент
A. Толбо
B. Нөсөө
C. Тав
D. Шалбархай
E. Ургацаг

/16./ Цэврүүтэх өвчнийг оношилод дараах шинж тэмдгийн аль нь илрэх вэ?
A. Манту-гийн сорил
B. Иодын сорил
C. Никольскийн шинж
D. Ауспицын шинж

/17./ Стивен Джонсоны хам шинж ямар өвчний үед илрэх вэ?
A. Ягаан үлд
B. Хайрст үлд
C. Хавтгай улаан үлд
D. Олон өнгөт үлд
E. Олон хэлбэрт шүүдэст улайрал

/18./ Үү халдварлахгүй зам
A. Мал амьтан
B. Хүнээс
C. Бохирлогдсон эд зүйл
D. Хоол хүнс

/19./ Дерма-д аль давхарга хамаарах вэ?
A. Торлог
B. Эвэрлэг
C. Мөхлөгт
D. Өргөст

/20./ Хайрст үлд өвчний үед ямар тууралт гарах вэ?
A. Зангилаа
B. Хайрст гөвдрүү
C. Ширшил
D. Бэлцрүү

/21./ Мөөгөнцөрт өвчин ямар замаар халдварлахгүй вэ?
A. Агаар дусал
B. Хувцас хэрэглэл
C. Халдвартай амьтнаас
D. Саун, усан сан

/22./ Арьсны идээт өвчнийг нэрлэнэ үү
A. Үү
B. Хайрст үлд
C. Сэвх
D. Намарс
E. Түүхий

/23./ Хяргагч үлд юунаас халдварлах вэ?
A. Хөрснөөс
B. Ургамлаас
C. Шавьжнаас
D. Амьтнаас

/24./ Үсний ил хэсэгт дараах бүтцүүдээс аль нь байдаггүй вэ?
A. Тархилаг давхарга
B. Холтослог давхарга
C. Хөхлөг
D. Булцуу
E. Ээрүүл хэлбэрийн эсүүд

/25./ Гипергидроз гэж юу вэ?
A. Тосны булчирхайн шүүрлийн ялгарал ихсэх
B. Хөлсний булчирхайн шүүрлийн ялгарал ихсэх
C. Хөлсний булчирхайн шүүрэл шингэрэх
D. Хөлсний булчирхайн шүүрэл үнэртэй болох

/26./ Вирусын шалтгаант арьсны өвчин
A. Энгийн хомхой
B. Түүхий
C. Хатиг
D. Хавтгай улаан үлд

/27./ Атопик дерматитын үед иммунологийн шинжилгээнд ямар өөрчлөлт гарах вэ?
A. Т-лимфоцит буурна

B. IgA буурна
C. IgG өснө
D. IgM буурна
E. IgE өснө

/28./ Хавьтал харшлын дерматитийг оношилох гол арга
A. Эмнэлзүй
B. Арьсны эдийн шинжилгээ
C. Иодын сорил
D. Арьсны сорил

/29./ Арьсны дайвар эрхтэнүүд
A. Үс, хумс
B. Хайрс
C. Сорви

/30./ Хяргагч үлдийн үүсгэгч
A. Стафилакокк
B. Стрептококк
C. Варицелла зостер вирус
D. Трихофитон
E. Хачиг

**Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )**

1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (B.)
2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
Бүх хариулт зөв бол (E.)

/31./ Өнгөн хөрсөнд байдаггүй эсийг дурдана уу?
A. Эпителиоцит
B. Мерклегийн эс
C. Лангергансийн эс
D. Фибробласт
E. Меланоцит

/32./ Тархмал хэлбэрийн улаан чонон яр өвчний үед эмнэл зүйн ямар шинж тэмдэг илэрдэг вэ?
A. Нүүрний арьсан дээр улайрал, нэвчдэс, хайрс, хатингаршил бүхий тод ирмэг захтай голомт бий болох
B. Биеийн аль нэг хэсэгт люпус панникулит бий болох
C. Ихэчлэн нүүрэн дээр хайрс болон хатингаршил байхгүй улайрал, үл мэдэг гуужилт бий болох
D. Биеэр тархмал, зах ирмэг нь тод биш, өнгөц, улайрал байдлаар илрэх жижиг голомтууд бий болох
E. Нүүрэнд эрвээхэй хэлбэрийн толбо гарах, Роуэлийн синдром бий болох, цусанд LE эс үүсэх

/33./ Та өвчтөнд арьсны өнгөц хяргагч үлд гэсэн онош тавьж байгаа бол ямар тосыг сонгох вэ?
A. Sp.Methyleni blau
B. Ung. Ac.Salicilicy
C. Ung. Zincy oxydati
D. Ung. Terbinafin
E. Ung. Streptocidi albi

/34./ Дараах шинжээр эктим өвчнийг оношлоно.
A. Үсний хүүдийн амсрын идээт цэврүү
B. Хуйханд бор өнгийн тав үүсэх
C. Товруун тууралт

D. Хөлийн шилбэнд цус идээт тавтай, шарх үүсэх
E. Хөлийн шилбэнд тод зааггүй, ус шүүстэй голомт үүсэх

/35./ Паракератоз:
A. Суурин давхарт бүтцийн өөрчлөлт
B. Өргөст давхар зузаарах
C. Үрлэг давхаргүй болох
D. Эвэрлэг давхарт эсийн бөөм бий болох
E. Тунгалаг давхаргүй болох

/36./ Жинхэнэ цэврүүтэлийн үед хэрэглэх үндсэн эмчилгээг сонгоно уу?
A. Антибиотик болон сульфаниламид
B. Цитостатик болон гистамины эсрэг бэлдмэл
C. Малярийн эсрэг болон иммуномодулятор
D. Кортикостироид болон цитостатик
E. Витамин болон антидепрессант

/37./ Чонон хөрвөсийн эмчилгээний эхний сонголтын эм
A. Нянгийн эсрэг эм
B. Гэдэс дотрын хямралыг арилгах
C. Гормонтой тос
D. Гистамины эсрэг эм
E. Витамин

/38./ Апокрин хөлсний булчирхайн шүүрэл ялгаруулах онцлог:
A. Булчирхайн эсүүд бүхэлдээ задрах
B. Булчирхайн эсийн доод хагас задрах
C. Булчирхайн эсүүд бүхэлдээ задрахгүй
D. Булчирхайн эсийн оройн хэсэг задрах
E. Булчирхайн эсийн доод хэсэг задрах

/39./ Олон өнгөт үлдийн үүсгэгч аль нь вэ?
A. Tr. Violaceum
B. Tr. Faveforme
C. Mr. lanosum
D. Pityrosporum orbicularae
E. Mr. canis

/40./ Зөгийн бал шиг шаргал өнгийн тав ямар ямар өвчний үед илэрч болох вэ?
A. Идээт нэвчдэст хяргагч үлд
B. Гүн түүхий
C. Хатиг
D. Өнгөц түүхий
E. Цэврүүтэх өвчин

/41./ Биеийн нугалаат хэсэг, нүүрэнд түрхэх кортикостеройдын үйлчлэлийн хүч ямар байх нь зүйтэй вэ?
A. Саармаг
B. Дунд
C. Хүчтэй
D. Сул хүчтэй
E. Их хүчтэй

/42./ Гиперкератоз гэдэг нь:
A. Дермийн хөхлөг давхрын эмгэг
B. Өргөст давхрагийн эсүүдийн хоорондох холбоос тасрах
C. Үрлэг давхар зузаарах
D. Эвэрлэг давхрага зузаарах
E. Үрлэг давхаргүй болох

/43./ Өнгөц түүхий өвчний бусад хэлбэрийг дурдана уу
A. Pityriasis lichenoides
B. Pityriasis versicolor
C. Pityriasis symplex

D. Pityriasis alba
E. Pityriasis rubra pilaris

/44./ Жинхэнэ арьсанд ямар эсүүд байдаггүй вэ?
A. Гистиоцит
B. Фибробласт
C. Эдийн базофил
D. Эпидермоцит
E. Макрофаг

/45./ Иммунофлюоресценцийн шинжилгээнд IgA эсрэгбие жинхэнэ арьсны хөхлөгт илэрч байвал та ямар өвчний тухай бодох вэ?
A. Цэврүүт пемфигойд
B. Жинхэнэ цэврүүтэх өвчин
C. Цэврүүт түүхий
D. Дюрингийн дерматит
E. Тэмбүүгийн цэврүүдэл

/46./ Өвдөлтийг аль нь мэдэрдэг вэ?
A. Колбо Краузе
B. Меркелийн эс
C. Мейснерийн биенцэр
D. Ноцирецептор
E. Руффини биенцэр

/47./ Нейродермитийн үед ямар тууралт гарах вэ?
1. Зангилаа, сорви
2. Зулгархай, цууралт
3. Цэврүү, шалбархай
4. Ширшил, гүвдрүү
5. Тав, хайрс

/48./ Өвчтөн А. 25 настай, эрэгтэй.
Бие загатнана, арьсан дээр юм гарсан гэсэн зовиууртай өрхийн эмчид үзүүлсэн.
Anamnesis morbe: Энэ удаа тууралт хэд хоногийн өмнөөс гарч эхэлсэн. Энэ нь 5 дахь удаагийн дахилт. 2 удаа эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байсан.
Anamnesis vitae: Ам бүл 5. Өвөө болон үеэл дүү нь ийм өвчтэй гэнэ. Ямар нэг харшилдаг эм, хоол хүнсний зүйл байдаг эсэхийг мэдэхгүй.
Status praecens: Үзлэгээр биеийн ерөнхий байдал сайн, байрлал идэвхитэй, асуултанд зөв хариулна. Арьс ердийн өнгөтэй, арьсан дорх өөхөн эдийн хөгжил дунд зэрэг, арьсны зурчлаа улаан, арьсны уян чанар сайн. Гүйлсэн булчирхай нь хоёр талдаа томорсон, улайсан байв.
Status localis: Өвчтний ар нуруу, дээд мөчний гадна гадаргуу, гуя, шилбэний өмнө хэсгээр тархмал, хайрсаар хучигдсан гүвдрүүт тууралт гарсан байв. Дээрх өгөгдлийг уншаад та ямар өвчин гэж бодож байна вэ?
A. Хавтгай улаан үлд
B. Ягаан үлд
C. Гүвдрүүт тэмбүүнцэр
D. Хайрст үлд
E. Хордлого харшлын дерматит

/49./ Лайеллийн хам шинжийн үед ямар эмийг яаралтай хэрэглэх вэ?
A. Антибиотик
B. Сульфаниламид
C. Витамин
D. Кортикостероид
E. Нойрсуулах бэлдмэл

/50./ Дюрингийн дерматитийн үед хамгийн түрүүнд сонгох эм аль нь вэ?
A. Кортикостероид
B. Цитостатик
C. Антибиотик

D. Сульфоны бүлэг
E. Иммуномодулятор

/51./ Өвчтөн өчигдөр орой бие их загатнан, том том юм гарсан. Одоо харин алга болчихлоо гэсээр таньд үзүүлбэл та ямар оношийг хамгийн түрүүнд бодох вэ?
A. Харшлын дерматит
B. Улаан чонон яр
C. Хордлогот дерматит
D. Чонон хөрвөс
E. Ягаан үлд

/52./ Шүүдэст хайрст үлд өвчний цочмог үед дараах эмчилгээг хийхгүй:
A. Антигистамины бэлдмэл
B. Гипосульфат натри
C. 1% салицилийн тос
D. Кортикостеройд тарих, уух
E. Кальци глюконат

/53./ Кебнерийн харийн урвал гэдэг нь :
A. Толгойн үс хуйхны үс хугарч унах
B. Бай төст шинж
C. Эх толбо үүсэх
D. Цочроосон газар шинээр гүвдрүү үүсэх
E. Тохойд идээт бохир тав хайрс үүсэх

/54./ Эмийн бодисийн арьсанд шингэх нь дараах зүйлээс хамаарахгүй:
A. Эмийн бодисийн физик-химийн шинж чанар
B. Өвчтний нас
C. Биеийн температур
D. Арьсны өнгө
E. Арьсанд гарсан эмгэг өөрчлөлтүүд

/55./ Уямангийн үүсгэгч аль нь вэ?
A. Вирус
B. Актиномицелл
C. Стафилококк
D. Микобактер Ганзена
E. Микобактер

/56./ Сургуулийн дунд ангийн хүүхэд зуныхаа амралтаар хөдөө, мал хариулж амарчээ. Гэртээ ирээд удалгүй арьсан дээр нь тууралт гарлаа гэсэн өгүүлэлтэй бол та хамгийн түрүүнд арьсны ямар өвчний талаар бодох вэ?
A. Арьсны үрэвсэл
B. Хамуу
C. Идээт өвчин
D. Арьсны үлд
E. Вирусын өвчин

/57./ Өвчтөн А. 25 настай, эрэгтэй.
Бие загатнана, арьсан дээр юм гарсан гэсэн зовиуртай өрхийн эмчид үзүүлсэн.
Anamnesis morbe: Энэ удаа тууралт хэд хоногийн өмнөөс гарч эхэлсэн. Энэ нь 5 дахь удаагийн дахилт. 2 удаа эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байсан.
Anamnesis vitae: Ам бүл 5. Өвөө болон үеэл дүү нь ийм өвчтэй гэнэ. Ямар нэг харшилдаг эм, хоол хүнсний зүйл байдаг эсэхийг мэдэхгүй.
Status praecens: Үзлэгээр биеийн ерөнхий байдал сайн, байрлал идэвхитэй, асуултанд зөв хариулна. Арьс ердийн өнгөтэй, арьсан дорх өөхөн эдийн хөгжил дунд зэрэг, арьсны зурчлаа улаан, арьсны уян чанар сайн. Гүйлсэн булчирхай нь хоёр талдаа томорсон, улайсан байв.
Status localis: Өвчтний ар нуруу, дээд мөчний гадна гадаргуу, гуя, шилбэний өмнө хэсгээр тархмал, хайрсаар хучигдсан гүвдрүүт тууралт гарсан байв. Онош батлахын тулд ямар шинжилгээг хийх хэрэгтэй вэ?
A. Цусны ерөнхий шинжилгээ

B. Шээсний шинжилгээ
C. Наалдцын шинжилгээ
D. Эдийн шинжилгээ
E. Серологийн шинжилгээ

/58./ Арьсны хөрсөн давхарт антиген илчлэгч эсийг нэрлэнэ үү?
A. Кератиноцит
B. Т-лимфоцит
C. Меланоцит
D. Лангергансийн эс
E. Меркелийн эс

/59./ Хуйх ба арьсны үлд өвчнөөр зонхилон хэн өвчлөх вэ?
A. Төрөх насны эмэгтэйчүүд
B. Бэлгийн идэвхитэй амьдралтай хүмүүс
C. Настайчууд
D. Сургуулийн хүүхдүүд
E. Аль ч насныхан

/60./ Ямар өвчний үед глютенд хэт мэдрэг болсон байдаг вэ?
A. Энгийн герпес
B. Стивенс-Джонсоны хам шинж
C. Цэврүүт хөрс хайлал
D. Дюрингийн дерматит
E. Энгийн цэврүүтэл

/61./ Зулгархай гэж юу вэ?
A. Арьс хуурайшиж хагарах
B. Арьсны бүтэн байдал өнгөц алдагдсан
C. Арьсны бүтэн байдал гүн алдагдсан
D. Арьсан дээрх шугаман гэмтэл
E. Арьс загатнаснаас үүссэн шугаман гэмтэл

/62./ Нярай хүүхдэд арьсны голомтод түрхэх кортикостероидыг сонгоно уу?
A. Гидрокортизон бутират
B. Адвантан
C. Элоком
D. Гидрокортизон ацетат
E. Фторокорт

/63./ Гипергидроз гэж юу вэ?
A. Тосны булчирхайн шүүрлийн ялгарал ихсэх
B. Хөлсний булчирхайн шүүрэл шингэрэх
C. Хөлсний булчирхайн шүүрэл өтгөрөх
D. Хөлсний булчирхайн шүүрлийн ялгарал ихсэх
E. Хөлсний булчирхайн шүүрэл үнэртэй болох

/64./ Олон өнгөт үлдийг оношлоход дараах сорил тусална.
A. Ядассоны сорил
B. Сорилын эмчилгээ
C. Харшлын сорил
D. Бальцерийн сорил
E. Туберкулины сорил

/65./ Спонгиоз гэдэг нь:
A. Дермийн хөхлөг давхрага хэт ургалт
B. Үрлэг давхаргүй болох
C. Суурин давхрагад шүүдэс хуримтлагдах
D. Өргөст давхрын эсүүдийн хооронд хаван үүсэх
E. Өргөст давхрын эс дотор хаван үүсэх

/66./ UVB эмчилгээний үндсэн зарчим:
A. Т-эсийн дархлалыг идэвхжүүлэх
B. Бөөрний дээд булчирхайн үйл ажиллагааг идэвхжүүлэх

C. Эсийн мембраныг бэхжүүлэх
D. Эсийн хуваагдал, үржлийг дарангуйлах
E. Меланоцитуудыг идэвхжүүлэх

/67./ Десмоглейн 3 уураг тодорхойлогдвол ямар өвчний онош батлагдах вэ?
A. Цэврүүшил
B. Дюрингийн дерматит
C. Цэврүүт түүхий
D. Жинхэнэ цэврүүтэл
E. Герпесийн халдвар

/68./ Хамуу өвчний ховор тохиолддог хэлбэрийг хэрхэн нэрлэдэг вэ?
A. Лайеллийн
B. Хачатуряны
C. Бехчетийн
D. Норвегийн
E. Мунрогийн

/69./ Гломусийн биеийн үүрэг:
A. Хүртэхүйн
B. Мэдрэхүйн
C. Дархлалын
D. Арьсанд цусны урсгалыг түргэсгэх
E. Туянаас хамгаалах

/70./ Нянгийн экземийн эмнэл зүйн онцлог?
1. Голомтын зах хүрээ тод байх
2. Голомт идээт цэврүүнцэрүүдтэй байх
3. Голомт мөчдийн гадна гадаргуугаар байрлах
4. Голомт ус шүүс ихтэй байх
5. Голомт загатнаа ихтэй байх

/71./ Вирусийн шалтгаант арьсны өвчин
1. Үү
2. Халдварт моллюск
3. Энгийн герпес
4. Иж хайрст үлд
5. Ягаан үлд

/72./ Дайвовет эмийн найрлага
1. Кортикостеройд
2. Ветаметазоне + кальципотрине(calcipotriene)
3. Кальципотрине
4. Дархалаа зохицуулах
5. Дархлаа дарангуйлах

/73./ Дараах өвчнүүдээс аль нь удамшлын шалтгаант арьсны өвчин бэ?
1. Хейли-Хейлийн цэврүүтэх өвчин
2. Цэврүүт хөрс хайлал
3. Нярайн халдварт цэврүүтэлт
4. Ихтиоз төст цэврүүт улайрал
5. Гэрлийн шалтгаант цэцэг өвчин

/74./ Ретинойд ямар үйлдэл үзүүлэх вэ?
1. Үрэвслийн эсрэг
2. Эвэршлийн эсрэг
3. Дархлаа дарангуйлах
4. Тос ялгарлыг бууруулах
5. Дулаан үүсгэх

/75./ Хавтгай улаан үлд өвчин алийг гэмтээх вэ?
1. Хумс
2. Арьс
3. Үс

4. Салст
5. Тосны булчирхай

/76./ Сүрьеэгийн чоно яр өвчний үед ямар шинжийг тодорхойлох вэ?
1. Бенье Мещерскийн шинж
2. “Алимны нухаш” шинж
3. Ядассоны шинж
4. Зондын цөмрөх шинж
5. Өргөсний шинж

/77./ Гидраденит өвчний үед юу гэмтэх вэ?
1. Эккриний булчирхай
2. Үсний уут
3. Хөлсний булчирхай
4. Апокрин булчирхай
5. Голокрин булчирхай

/78./ Арьс арчилгааны үндсэн зарчим
1. Цэвэрлэх
2. Чийгшүүлэх
3. Хамгаалах
4. Гуужуулах
5. Тос түрхэх

/79./ Хуйхны бужуу үлдийг илэрхийлэх шинж:
1. Хуйханд  их хэмжээний хайрс үүсэх
2. Жийргийн шинж
3. Үс 6-8 мм-ийн түвшинд хугарсан байх
4. Цөөн голомт
5. Солонгын шинж

/80./ Атопийн дерматитын оношлогооны үндсэн шалгуурыг дурьдана уу?
1. Загатнаа
2. Гэр бүлд харшлын анамнез бүртгэгдэх
3. Архаг дахилтат явц
4. Арьс хуурайших
5. Хооллолт

/81./ Тцанкийн эсийг дараах өвчний оношлогоонд хэрэглэнэ.
1. Энгийн герпес
2. Жинхэнэ цэврүүтэл
3. Бүслүүр үлд
4. Цэврүүшил
5. IgA   дерматит

/82./ Гүйлсэн булчирхайн үрэвсэлт өвчний улмаас өвчтөнд эмч тетрациклин бичиж өгчээ. Өмнө нь хэд хэдэн удаа тэр эмийг ууж байсан. Эмчилгээний 2 дахь өдөр биеийн байдал сайжирч эхэлсэн боловч биеэр их хэмжээний улаан ягаан толбо гарч хорсож эхэлжээ. Таны эмнэл зүйн онош?
1. Харшил хавьтлын дерматит
2. Энгийн хавьтлын дерматит
3. Жинхэнэ хурц экзем
4. Хордлого харшлын дерматит
5. Хурц чонон хөрвөс

/83./ Хлоазм юунаас болж үүсдэг вэ?
1. Хэт ядарснаас
2. Дотоод шүүрлийн булчирхайн өөрчлөлт
3. Эм
4. Арьсанд нөсөө үүсэх явц идэвхижсэн
5. Арьсаа буруу арчилсан

/84./ Арьсны хоргүй хавдар:
1. Хажираст кератоз

2. Сирингом
3. Нөсөөт мэнгэ
4. Эвэршдэг эсийн хавдар
5. Меланом

/85./ Атопийн дерматитийн оношлогооны туслах шалгуур:
1. Арьс хуурайших
2. Арьсны халдварт өртөмхий болох
3. Денье Морганы шинж илрэх
4. Голомт тархмал байх
5. Архаг дахилтат явц

/86./ Дараах өвчнйи үед салстад туурал гарна.
1. Leucoplacia
2. Pemphigus
3. Alopecia
4. Lichen planus
5. Pemphigoid

/87./ Өнгөц түүхий өвчний үед ямар эмчилгээ хийх вэ?
1. Гормонтой тос
2. Анилины будаг
3. Витамин
4. Антибиотиктой тос
5. УВЧ шарлага

/88./ Аденома нь:
1. Хорт хавдар
2. Хоргүй хавдар
3. Мезенхим эдээс гаралтай
4. Булчирхайлаг эпителээс гаралтай
5. Меланоцит эсээс гаралтай

/89./ Хавьтал харшил хавьтлын дерматитийн эмчилгээ
1. Цочруулын үйлчлэлийг зогсоох
2. Гистамины бэлдмэл уулгах
3. Эмнэлзүйд үндэслэн шавшлага болон тос хэрэглэх
4. Ходоод угаах
5. ПУВА эмчилгээ

/90./ LED буюу зээрэнцэг маягийн улаан чонон яр өвчний эмнэлзүйн үндсэн шинж:
1. Эрвээхэй хэлбэрийн толбо
2. Нягт хайрс
3. Арьс хатингирших
4. Загатнаа
5. Нойргүйдэл

/91./ Энгийн герпесийн үед эдийн шинжилгээнд ямар өөрчлөлт гарах вэ?
1. Гранулез
2. Акантоз
3. Потрийн бичил буглаа
4. Эс доторхи хаван
5. Гиперкератоз

/92./ Хайрст үлд өвчний үед гарах патогистологийн өөрчлөлт ?
1. Акантоз
2. Мунрогийн микроабсцесс
3. Паракератоз
4. Спонгиоз
5. Потриегийн микроабсцесс

/93./ Мөөгөнцөрт өвчин яаж халдах вэ?
1. Агаар дуслаар
2. Шууд хавьтлаар

3. Хоол хүнсээр
4. Шууд бус замаар
5. Шумуулаар

/94./ Өвчтөн Ц. 5 настай, эмэгтэй.
Ээжийн өгүүллээр хүүхдийн нүүрэнд юм гарч ихсээд байна гэсээр өрхийн эмчид үзүүлсэн.
Anamnesis morbe: Хоёр хоногийн өмнө амны буланд шүүстэй юм гарсан. Амархан үсэрхийлсэн. Анх удаа өвчилж байна. Гэрээр ямар нэг эмчилгээ хийгээгүй гэнэ.
Anamnesis vitae: Хүүхэд аав, ээжийнхээ хамт амьдардаг. Цэцэрлэгт явдаг. Ямар нэг халдварт өвчнөөр өвчлөөгүй.
Status praecens: Хүүхдийн биеийн ерөнхий байдал сайн, байрлал идэвхитэй. Хүүхдийн өсөлт хөгжил насандаа тохирсон. Арьс ердийн өнгөтэй, арьсан дорх өөхөн эдийн хөгжил дунд зэрэг, арьсны зурчлаа улаан байв.
Status localis: Хүүхдийн нүүрээр, ялангуяа амны эргэн тойрон, хацраар зөгийн бал шиг шаргал өнгийн зузаан тавтай байв. Баруун гарын шуу сарвууны орчим мөн адил зузаан тавтай байна. Фликтен дараах шинжийг агуулна.

1. Улбагар
2. Амархан хагардаг
3. Нимгэн бүрхүүлтэй
4. Зах руугаа тэлэх хандлагатай
5. Шингэн шаргал агуулагдахуунтай

/95./ Гүвдрүүт тууралтаар илэрдэг өвчнийг нэрлэнэ үү?

1. Хамуу
2. Хайрст үлд
3. Гүвдрүүт тэмбүүнцэр
4. Үү
5. Халдварт моллюск

/96./ Өвчтөн Ц. 5 настай, эмэгтэй.
Ээжийн өгүүллээр хүүхдийн нүүрэнд юм гарч ихсээд байна гэсээр өрхийн эмчид үзүүлсэн.
Anamnesis morbe: Хоёр хоногийн өмнө амны буланд шүүстэй юм гарсан. Амархан үсэрхийлсэн. Анх удаа өвчилж байна. Гэрээр ямар нэг эмчилгээ хийгээгүй гэнэ.
Anamnesis vitae: Хүүхэд аав, ээжийнхээ хамт амьдардаг. Цэцэрлэгт явдаг. Ямар нэг халдварт өвчнөөр өвчлөөгүй.
Status praecens: Хүүхдийн биеийн ерөнхий байдал сайн, байрлал идэвхитэй. Хүүхдийн өсөлт хөгжил насандаа тохирсон. Арьс ердийн өнгөтэй, арьсан дорх өөхөн эдийн хөгжил дунд зэрэг, арьсны зурчлаа улаан байв.
Status localis: Хүүхдийн нүүрээр, ялангуяа амны эргэн тойрон, хацраар зөгийн бал шиг шаргал өнгийн зузаан тавтай байв. Баруун гарын шуу сарвууны орчим мөн адил зузаан тавтай байна. Анхдагч ямар тууралтаас тав үүсэх вэ?

1. Цэврүү
2. Цэврүүнцэр
3. Идээт цэврүү
4. Гүвдрүү
5. Бэлцрүү

/97./ Хэсэг газарт хэрэглэсэн кортикостироидын гаж нөлөө:

1. Арьсны хатингиршил
2. Нөсөөжих
3. Судасжих
4. Арьс зузаарах
5. Арьс ховхрох

/98./ Чонон хөрвөс өвчний шалтгаан:

1. Нянгийн халдвар
2. Хүйтэн
3. Чичиргээ

4. Хоол хүнс
5. Эмийн бодис

/99./ Нярайд тохиолддог арьсны идээт өвчнийг нэрлэнэ үү?
1. Везикулопустулёз
2. Нярайн халдварт цэврүүтэлт
3. Риттерийн гуужилтат дерматит
4. Экзем
5. Потница

/100./ Капошийн саркомын эмнэлзүйн шинж:
1. Толгойн хуйханд
2. Толбо, гүвдрүү
3. Зангилаа, хайрс
4. Хөхөлбөр ягаан
5. Загатнаа их

/101./ Дайвонексийн (Daivonex) найрлага ба үйлдэл:
1. Кортикостеройд
2. Дархалаа зохицуулах
3. Ветаметазоне + кальципотрине(calcipotriene)
4. Кальципотрине
5. Дархлаа дарангуйлах

/102./ Хавтгай улаан үлд өвчний гүвдрүүний онцлог шинжүүдийг дурьдана уу?
1. Хөхөлбөр ягаан өнгөтэй
2. Төвдөө хүйс маягийн хонхорхойтой
3. Гялалзсан гадаргуутай
4. Олон өнцөгт хэлбэртэй
5. Хавтгай гадаргуутай

/103./ Дор дурдсан өвчнүүд гүвдрүүт тууралтаар илэрнэ.
1. Хайрст үлд
2. Хамуу
3. Нейродермит
4. Чонон хөрвөс
5. Экзем

/104./ Дюрингийн дерматитийг ямар өвчнөөс ялган оношлох вэ
1. Цэврүүт түүхий
2. Цэврүүт пемфигойд
3. Цэврүүт хэлбэрийн улаан хавтгай үлд
4. Жинхэнэ цэврүүтэл
5. Тархмал герпес

/105./ Зангилаат маажуурыг илэрхийлэх үндсэн шинж:
1. Гүвдрүүт цэврүүнцэр
2. Мөчдийн гадна гадаргууд голомт байрлах
3. Үү маягийн тууралт
4. Зангилаа маягийн гүвдрүү
5. Хөрзөн

/106./ 10 настай эрэгтэй хүүхэд үсээ засуулахаар очтол үсчин түүний үсийг засалгүй арьсны эмчид үзүүлэх зөвлөгөө өгөөд явуулсан байв. Яагаад тэр вэ?
1. Үс нь их хиртэй
2. Хуурстай
3. Себорейтэй
4. Хуйхны мөөгөнцөртэй
5. Хайрст үлдтэй

/107./ Нүүрний төвгөр хэсэгт голомт нь байрладаг арьсны өвчнийг нэрлэнэ үү?
1. Хүүхдийн экзем
2. Нарны экзем
3. Өнгөц түүхий

4. Улаан чонон яр
5. Энгийн герпес

/108./ Цэврүүтэл өвчнийг оношлох дархан туяарах арга нь:
1. Цэврүүтэл өвчнийг оношлох дархан туяарах арга нь:
2. Үрлэг давхарт эсрэгбие илрүүлнэ
3. Суурийн давхрын эс хоорондын холбоонд эсрэгбие илрүүлнэ
4. Өргөс давхрын эс хоорондын холбоонд эсрэгбие илрүүлнэ
5. Өргөс ба эвэрлэг давхарт эсрэгбие илрүүлнэ

/109./ Арьсны идээт өвчин үүсэхэд дараах хүчин зүйл нөлөөлнө.
1. Арьсны бүрэн бүтэн байдал алдагдах
2. Арьсны Ph өөрчлөгдөх
3. Цусанд сахарын хэмжээ ихсэх
4. Дархлалын үйл ажиллагаа алдагдах
5. Арьсан дээрх нянгийн тоо ихсэх

/110./ Хумс дараах өвчний үед гэмтэнэ.
1. Хавтгай улаан үлд
2. Тавхайн мөөгөнцөр
3. Ихтиоз
4. Хумсны меланом
5. Хажираст дерматит

/111./ Хордлого харшлын дерматитийн хүнд хэлбэр - Лайеллын хам шинжийн үед ямар шинж тэмдэг илрэх вэ?
1. Өвчин гэнэт эхэлнэ.
2. Өвчтөн  халуурна.
3. Өвчтөний биеийн байдал сульдаж доройтно
4. Арьс салстанд цэврүү туурч, арьс хөрсгүй болж өвдөлттэй байна.
5. Никольскийн шинж илэрнэ.

/112./ Хуйхны өнгөц хяргагч үлдийн үед илрэх шинжийг тодруулна уу?
1. Зөгийн үүрийн шинж
2. Хожуулын шинж
3. Солонгын шинж
4. Хар цэгийн шинж
5. Жийргийн шинж

/113./ Батга өвчний эмнэлзүйн ямар хэлбэр сорви үүсгэх вэ
1. Цагаан батга
2. Конглобат
3. Ягаан батга
4. Буглаат
5. Гүвдрүүт батга

/114./ Нейродерматозын бүлэг өвчинд дараах өвчин хамаарна.
1. Маажуур
2. Арьсны загатнаа
3. Нейродерматоз
4. Чонон хөрвөс
5. Экзем

/115./ Арьсны хорт хавдар
1. Хажираст кератоз
2. Сирингом
3. Нөсөөт мэнгэ
4. Эвэршдэг эсийн хавдар
5. Гемангиом

/116./ Хайрст үлдийн голомт хаана зонхилон байрлах вэ?
1. Тохой
2. Өвдөг
3. Хуйх

4. Нүүр
5. Хэвлийн өмнө хэсэг

/117./ Хяргагч үлдийн үед юу гэмтэж болох вэ?

1. Арьс
2. Толгойн үстэй хэсэг
3. Хумс
4. Шээсний сүв
5. Салст

/118./ Ямар өвчний үед аманд цэврүүт тууралт гарах вэ?

1. Цэврүүтэх өвчин
2. Олон хэлбэрт шүүдэст улайрал
3. Энгийн герпес
4. Дюрингийн өвчин
5. Хавтгай улаан үлд

/119./ Өвчтөн А. 25 настай, эрэгтэй. Бие загатнана, арьсан дээр юм гарсан гэсэн зовиуртай өрхийн эмчид үзүүлсэн. Anamnesis morbe: Энэ удаа тууралт хэд хоногийн өмнөөс гарч эхэлсэн. Энэ нь 5 дахь удаагийн дахилт. 2 удаа эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байсан.

Anamnesis vitae: Ам бүл 5. Өвөө болон үеэл дүү нь ийм өвчтэй гэнэ. Ямар нэг харшилдаг эм, хоол хүнсний зүйл байдаг эсэхийг мэдэхгүй. Status praecens: Үзлэгээр биеийн ерөнхий байдал сайн, байрлал идэвхитэй, асуултанд зөв хариулна. Арьс ердийн өнгөтэй, арьсан дорх өөхөн эдийн хөгжил дунд зэрэг, арьсны зурчлаа улаан, арьсны уян чанар сайн. Гүйлсэн булчирхай нь хоёр талдаа томорсон, улайсан байв. Status localis: Өвчтний ар нуруу, дээд мөчний гадна гадаргуу, гуя, шилбэний өмнө хэсгээр тархмал, хайрсаар хучигдсан гүвдрүүт тууралт гарсан байв. Арьсанд дараах өөрчлөлтийн улмаас гүвдрүүт тууралт гарна.

1. Арьсны өнгөн хөрсний өсөлтийн давхрын эсийн хэт ургалт
2. Жинхэнэ арьсны хөхлөгт эсийн нэвчдэс хуралдах
3. Арьсны өнгөц давхарт ямар нэг бодис хуралдах
4. Жинхэнэ арьсанд эсийн нэвчдэс хуралдах
5. Арьсны эвэрлэг давхар зузаарах

/120./ Өвчтөн А. 25 настай, эрэгтэй.

Бие загатнана, арьсан дээр юм гарсан гэсэн зовиуртай өрхийн эмчид үзүүлсэн.

Anamnesis morbe: Энэ удаа тууралт хэд хоногийн өмнөөс гарч эхэлсэн. Энэ нь 5 дахь удаагийн дахилт. 2 удаа эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байсан.

Anamnesis vitae: Ам бүл 5. Өвөө болон үеэл дүү нь ийм өвчтэй гэнэ. Ямар нэг харшилдаг эм, хоол хүнсний зүйл байдаг эсэхийг мэдэхгүй.

Status praecens: Үзлэгээр биеийн ерөнхий байдал сайн, байрлал идэвхитэй, асуултанд зөв хариулна. Арьс ердийн өнгөтэй, арьсан дорх өөхөн эдийн хөгжил дунд зэрэг, арьсны зурчлаа улаан, арьсны уян чанар сайн. Гүйлсэн булчирхай нь хоёр талдаа томорсон, улайсан байв.

Status localis: Өвчтний ар нуруу, дээд мөчний гадна гадаргуу, гуя, шилбэний өмнө хэсгээр тархмал, хайрсаар хучигдсан гүвдрүүт тууралт гарсан байв. Дээрх өгөгдлийг уншаад энэ өвчний шалтгаан эмгэг жамд ямар хүчин зүйл нөлөөлсөн байж болох вэ?

1. Сэтгэл санааны хямрал
2. Халдвар харшил
3. Дотоод шүүрлийн эмгэг
4. Удамшил
5. Бодисын солилцооны өөрчлөлт

/121./ Хүүхдийн экзем буюу атопийн дерматит үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлс аль нь вэ?

1. Төрөх хүчний сулрал
2. Жирэмсэн үеийн хооллолт
3. Хүүхдийн асаргаа
4. Жирэмсний хордлого
5. Гоо сайхны бүтээгдэхүүн

/122./ Ягаан үлд өвчний үед эмнэл зүйн ямар шинж илрэх вэ
1. Үрчгэр тамхины цаасны шинж
2. Медальоны шинж
3. Эх ба охин толбо
4. Эритема
5. Зулгархай

/123./ Онош тодруулахын тулд гүвдрүүт тууралтаас биопси авав. Эдийн шинжилгээнд үрлэг давхрын эгнээ олширсон байлаа. Үүнийг эмч юу гэж тодорхойлон бичих вэ?
1. Акантоз
2. Спонгиоз
3. Паракератоз
4. Гранулез
5. Экзоцитоз

/124./ Атопийн дерматитийн үед лабораторийн шинжилгээнд дараах өөрчлөлт давамгайлна:
1. Лейкоцитоз
2. Эозинофил олшрох
3. Т-лимфоцитын тоо цөөрөх
4. Ig E хэмжээ ихсэх
5. Улаан эсийн тунах хурд ихсэх

/125./ Ямар тохиолдолд тослог арьс гэж үзэх вэ?
1. Батгаших хандлагатай
2. Тос даарварласан
3. Бохирдохдоо амархан
4. Үрчийх хандлагатай
5. Мэдрэг

/126./ Өвчтөн Ц. 5 настай, эмэгтэй.

Ээжийн өгүүллээр хүүхдийн нүүрэнд юм гарч ихсээд байна гэсээр өрхийн эмчид үзүүлсэн.

Anamnesis morbe: Хоёр хоногийн өмнө амны буланд шүүстэй юм гарсан. Амархан үсэрхийлсэн. Анх удаа өвчилж байна. Гэрээр ямар нэг эмчилгээ хийгээгүй гэнэ.

Anamnesis vitae: Хүүхэд аав, ээжийнхээ хамт амьдардаг. Цэцэрлэгт явдаг. Ямар нэг халдварт өвчнөөр өвчлөөгүй.

Status praecens: Хүүхдийн биеийн ерөнхий байдал сайн, байрлал идэвхитэй. Хүүхдийн өсөлт хөгжил насандаа тохирсон. Арьс ердийн өнгөтэй, арьсан дорх өөхөн эдийн хөгжил дунд зэрэг, арьсны зурчлаа улаан байв.

Status localis: Хүүхдийн нүүрээр, ялангуяа амны эргэн тойрон, хацраар зөгийн бал шиг шаргал өнгийн зузаан тавтай байв. Баруун гарын шуу сарвууны орчим мөн адил зузаан тавтай байна. Энэ тохиолдолд ямар арга хэмжээг авах вэ?
1. Нүүр угаахыг хориглох
2. Нүүр, гарыг спиртийн уусмалаар арчих
3. Будагч бодис түрхэх
4. Шавшлага хийх
5. Гистамины эсрэг эм уулгах

/127./ Ретинойдыг хэрэглэх үед гарах сөрөг нөлөө
1. Арьс хэт хуурайших
2. Урагт нөлөөлөх
3. Өөх тосны солилцоо алдагдах
4. Лейкоцитоз
5. Бөөрний дутагдал

/128./ Үсний ургалтын фазыг нэрлэнэ үү?
1. Анаген
2. Телоген
3. Катаген
4. Анафаз

5. Телефаз

/129./ Хавьтал харшлын дерматитын онцлог юу вэ

1. Ямар нэг харшил төрүүлэгч үйлчилсний улмаас эмнэлзүйн шинж тэмдэг илэрнэ
2. Цочрол үйлчилсэн газраас үрэвслийн голомт тэлж томорно.
3. Арьсны үрэвслийн шинж тод илрэнэ
4. Эмнэлзүйн шинж нь цочруулын шинжийг  хадгална.
5. Нөхцөлт бус цочруулаар үүсгэгдэнэ.

/130./ Бүслүүр үлд өвчний үед дараах шинж илэрнэ

1. Гэмтсэн мэдрэлийн судлын дагуу өвдөх, хорсох
2. Арьс улайж үрэвсэх
3. Бүлэглэсэн жижиг цэврүүцэр гарах
4. Тархмал жижиг цэврүүнцэр гарах
5. Ороож бүсэлж өвдөх

**<u>Сорилын зөв хариулт -Сорил-1</u>**

1-A, 2-D, 3-D, 4-B, 5-E, 6-E, 7-E, 8-D, 9-D, 10-D, 11-D, 12-C, 13-B, 14-C, 15-A, 16-C, 17-E, 18-D, 19-A, 20-B, 21-A, 22-E, 23-D, 24-D, 25-B, 26-A, 27-E, 28-D, 29-A, 30-D, 31-D, 32-D, 33-D, 34-D, 35-D, 36-D, 37-D, 38-D, 39-D, 40-D, 41-D, 42-D, 43-D, 44-D, 45-D, 46-D, 47-C, 48-D, 49-D, 50-D, 51-D, 52-D, 53-D, 54-D, 55-D, 56-D, 57-D, 58-D, 59-D, 60-D, 61-D, 62-D, 63-D, 64-D, 65-D, 66-D, 67-D, 68-D, 69-D, 70-A, 71-A, 72-C, 73-C, 74-C, 75-C, 76-C, 77-D, 78-A, 79-A, 80-A, 81-A, 82-D, 83-C, 84-A, 85-A, 86-C, 87-C, 88-C, 89-A, 90-A, 91-D, 92-A, 93-C, 94-E, 95-E, 96-A, 97-A, 98-E, 99-A, 100-C, 101-C, 102-E, 103-A, 104-C, 105-C, 106-C, 107-C, 108-D, 109-E, 110-C, 111-E, 112-C, 113-C, 114-A, 115-D, 116-A, 117-A, 118-A, 119-A, 120-C, 121-C, 122-A, 123-D, 124-C, 125-A, 126-A, 127-A, 128-A, 129-A, 130-A,

**Тохиолдол 1**

Өвчтөн Х 5 настай, охин.

**Зовиур:** Ээжийн өгүүллээр хүүхдийн нүүрэнд юм гарч ихсээд байна гэсээр өрхийн эмчид үзүүлсэн.

Anamnesis morbi: Хоёр хоногийн өмнө амны буланд шүүстэй юм гарсан. Амархан үсэрхийлсэн. Анх удаа өвчилж байна. Гэрээр ямар нэг эмчилгээ хийгээгүй гэнэ.

**Anamnesis vitae:** Хүүхэд аав, ээжийнхээ хамт амьдардаг. Цэцэрлэгт явдаг. Ямар нэг халдварт өвчнөөр өвчлөөгүй.

**Status praecens obj:** Хүүхдийн биеийн ерөнхий байдал сайн, байрлал идэвхитэй.

**Status localis:** Хүүхдийн нүүрээр, ялангуяа амны эргэн тойрон, хацраар зөгийн бал шиг шаргал өнгийн зузаан тавтай байсан.Тав ховхорсон газар  идээрхэг шингэнтэй шалбархайтай байв.Баруун гарын шуу сарвууны орчим мөн адил зузаан тавтай байна.

**1. Анхдагч ямар тууралтаас тав үүсэх вэ?**

1. Цэврүү
2. Цэврүүнцэр
3. Идээт цэврүү
4. Гүвдрүү
5. Бэлцрүү

**2. Фликтен дараах шинжийг агуулна:**

1. Улбагар

2. Амархан хагардаг
3. Нимгэн бүрхүүлтэй
4. Захруугаа тэлэх хандлагатай
5. Шингэн шаргал агуулагдахуунтай

**3. Дээрхи өвчний шалтгаан:**

A. Вирус
B. Стаффилококк
C. Стрептококк
D. Мөөгөнцөр
E. Хачиг

**4. Уг өвчнийг ямар өвчнүүдтэй ялган оношлох шаардлагатай вэ?**

1. Хомхой
2. Гүн түүхий
3. Идээт нэвчдэст хяргагч үлд
4. Хатиг
5. Цэврүүтэх өвчин

**5. Уг өвчний үед дараах арга хэмжээ авна:**

1. Нүүр угаахыг хориглоно
2. Нүүр гарыг спиртийн уусмалаар арчих
3. Будагч бодис түрхэх
4. Шавшлага хийх
5. Гистамины эсрэг эм уулгах

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| A | E | C | B | A |

**Тохиолдол2**

Өвчтөн Д, 6 настай, охин

**Зовиур:** Ээж нь охиныгоо шөнө унтаж байхдаа биеэ их маажиж байна, бас биеэр нь тууралт гарсан гэж ярив.

**Anamnesis morbi:** Эхийн ажигласнаар энэ зовиур 10-аад хоногийн өмнө эхэлсэн байна. Цэцэрлэгийн ангид нь ийм тууралттай хүүхэд байсан гэдгийг багшаас нь мэдсэн. Эх нь охинтойгоо унтдаг, эхийн гарын сарвуу, хэвлийгээр тууралт гарч загатнаж эхэлсэн байв.

**Anamnesis vitae:** 1 нас хүртлээ хөхөө хөхөж байсан. Өсөлт бойжилт насандаа тохирсон. Цэцэрлэгт явдаг. Салхин цэцгээр өвдсөн.

**Status praecens obj:** Хүүхдийнбиеийн ерөнхий байдал дунд зэрэг, ухаан саруул, байрлал идэвхитэй. Арьсны өнгө ердийн, арьсан доорх өөхөн эдийн хөгжил дунд зэрэг, арьсны зурчлаа улаан.

**Status localis:** Хэвлийн өмнө хэсэг, хоёр гарын шуу, хуруунь салаа, гуяны дотор талаар хос хосоороо байрласан тархмал тууралттай. Зарим хэсэгт цусархаг тавтай. Горчакова Ардын шинж илэрсэн байв.

**1. Дээрх тохиолдолын өгүүллээс чухам аль аль нь таныг хамуу өвчин гэж бодоход хүргэж байна вэ?**

1. Ангийн хүүхэд нь ийм өвчтэй байсан
2. Шөнө загатнадаг, тууралт гарсан гэсэн зовиуртай
3. 10-аад хоногийн өмнөөс зовиур эхэлсэн
4. Эхэд нь бас ийм тууралт гарсан
5. Хос хосоороо байрласан тархмал тууралттай

**2. Хамуу өвчний үүсгэгчийг нэрлэнэ үү?**

A. Pediculoides ventricosis
B. Sarcoptes scabiei hominis

C. Sarcoptis demodex hominis
D. Pediculi pubis
E. Human papiloma virusis

**3. Хамуу өвчний үед ямар анхдагч тууралт гардаг вэ?**

A. Гүвдрүү хайрс
B. Гүвдрүү ширшил
C. Гүвдрүү товруу
D. Гүвдрүүт цэврүүнцэр
E. Гүвдрүү бэлцрүү

**4. Хамуу өвчний эмчилгээнд дараах эмийг хэрэглэнэ.**

1. Ung. Zincy oxydati 10%
2. Ung. Sulfurici 10%
3. Ung. Synaphlani 0.025%
4. Ung. Benzylbenzoati 10%
5. Ung. Flucinari 1%

**5. Та уг өвчтөнд ямар зөвлөгөө өгөх вэ?**

1. Эмчилгээний өмнө ба дараа усанд оруулах
2. Хүүхдийн эх болон гэр бүлийн гишүүдийг үзлэгт хамруулах
3. Хувцас, цагаан хэрэглэлийг ариутгах
4. Биеэ чийрэгжүүлэх
5. Хоолны дэглэм барих

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| E | B | A | C | A |

**Тохиолдол 3**

Өвчтөн М 35 настай, эрэгтэй

**Зовиур:** Баруун нүд орчмоор хүчтэй өвдөнө, нулимс гоожно, зовхи хавдана.

**Anamnesis morbi:** Долоо хоногийн өмнөөс нүдний дээд талаар өвдөж, зовхи улайсан. Дараа нь хавдар улам ихэссэн. Эмчилгээ хийгээгүй. Сүүлийн 6 сар хоолой хэд хэдэн удаа өвдөж, ханиад хүрсэн.

**Anamnesis vitae:** Ам бүл 2. Орчуулагч мэргэжилтэй.

**Status preacens obj:** Өвчтөний биеийн байдал дунд зэрэг, байрлал идэвхитэй.

**Status localis:** Нүүрний баруун дээд хэсэг буюу баруун нүдний дээд талд улайж хавагнана, олон тооны цэврүүнцэрүүд гарсан, зарим хэсгээр шалбархайтай.

**1. Та уг өвчнийг ямар ямар өвчнүүдтэй ялган оношлогоо хийх вэ?**

A. Энгийн герпес
B. Коньюктивит
C. Энгийн цэврүүтэх өвчин
D. Лайеллын хам шинж
E. Стивенс Джонсоны хам шинж

**2. Дээрх өгөгдөлд тохирохгүй нэг хариултыг олно уу?**

A. Мэдрэлийн судал дагасан өвдөлт
B. Бүлгээр байрласан цэврүүнцэрүүд
C. Харалдаа байрлалтай тууралт
D. Шалбархай, хоёрдогч толбо үүснэ
E. Гистологт ‘аварга эс’ илрэнэ

**3. Дээрх өвчтөний тохиолдолд чухам аль мэдрэлийн судал гэмтсэн байна вэ?**

A. Nervus facialis
B. Nervus ophtalmicus
C. Nervus maxillaries

D. Nervus intercostalis
E. Nervus auricularis

**4. Уг өвчтөнд хэсэг газрын ямар эмчилгээг та зөвлөх вэ?**

1. Ацикловир тос
2. Аналины будагч бодисууд
3. Физик эмчилгээ
4. Даавартай тос
5. Антибиотиктой тос

**5. Вирусийн шалтгаант арьсны өвчнийг дурдана уу?**

1. Ягаан үлд
2. Үү
3. Стивенс-Джонсоны хам шинж
4. Халдварт моллюск
5. Олон хэлбэрт шүүдэст улайрал

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| A | C | B | A | C |

**Тохиолдол 4**

Өвчтөн Б, 11 настай, эр

**Зовиур:** Халуурна, толгой өвдөнө, үсэн дотор юм гарсан гэнэ.

**Anamnesis morbi:** 10 хоногийн өмнөөс толгой дээр юм гарсан, аажмаар тэр нь томорч идээлсэн. Эмчилгээ хийлгээгүй.

**Anamnesis vitae:** Эхийнсүүгээр бойжсон, өсөлт бойжилт насандаа. 5-р ангид сурдаг. Ээж аав нь малын арьс ширний наймаа хийдэг учир тусладаг.

**Status preacens obj:** Биеийн ерөнхий байдал дунд зэрэг, ухаан саруул, байрлал идэвхитэй. Арьсны өнгө ердийн, арьсан доорх өөхөн эдийн хөгжил дунд зэрэг, арьсны зурчлаа улаан. Хүзүү, эрүүний доорх тунгалагийн зангилаа томорсон, эмзэглэлтэй.

**Status localis:** Хуйханд 3х6 см хэмжээтэй, зах ирмэг нь тод, нэвчдэстэй, идээрхэг тавтай голомт гарсан байв.

**1. Идээт нэвчдэст тууралтаар илэрдэг арьсны өвчнийг нэрлэнэ үү?**

1. Фолликулит
2. Идээт нэвчдэст хяргагч үлд
3. Хомхой
4. Сикоз
5. Түүхий

**2. Идээт нэвчдэст хяргагч үлдийн үед өөр ямар шинж илрэх вэ?**

1. Голомтонд байгаа үс суларсан
2. Дарахад хөндүүрлэж өвдөнө
3. Керион Цельсийн шинж
4. Голомт нь төв хэсэгтээ бамбалзах
5. Голомтонд үс хугарна

**3. Оношоо батлахын тулд та ямар шинжилгээ хийх вэ?**

1. Цусны ерөнхий шинжилгээ
2. Нян судлалын шинжилгээ
3. Шээсний ерөнхий шинжилгээ
4. Микологийн шинжилгээ
5. Эдийн шинжилгээ

**4.Та уг өвчнийг эмчлэхдээ ямар ямар зарчмыг баримтлах вэ?**

1. Голомтыг цэвэрлэх
2. Үрэвсэл намдаах эмчилгээ

3. Халдваргүйжүүлэх эмчилгээ
4. Мөөгөнцөрийн эсрэг эмчилгээ
5. УФО шарлага хийх

**5. Хяргагч үлд өвчний үүсгэгч аль нь вэ?**

1. Microsporum canis
2. Trichophyton verrucosum
3. Trichophyton rubrum
4. Trichophyton mentagrophytes
5. Epidermophytia floccosum

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| C | A | D | E | C |

**Тохиолдол 5**

Өвчтөн Ш, 54 настай, эрэгтэй

**Зовиур:** Ууцан  дээр тууралт гарсан, тууралтаас шүүс гарна, загатнаа ихтэй

**Anamnesis morbi:** Ууцны радикулитын өвдөлтийн улмаас ууцан дээрээ өвчин намдаах наалт наасан. Маргааш нь наалт наасан газар тууралт гараад шүүс гарсан байсан. Эмчилгээ хийлгээгүй.

**Anamnesis vitae:** Ам бүл 6, жолооч хийдэг.

**Status preacens obj:** Биеийн ерөнхий байдал дунд зэрэг, ухаан саруул, байрлал идэвхитэй. Арьсны өнгө ердийн, арьсан доорх өөхөн эдийн хөгжил их, арьсны зурчлаа улаан.

**Status localis:** Ууцан дээр наалт наасан хэсэгт улайсан, бага зэрэг хавагнасан суурин дээр гүвдрүүт, цэврүүт тууралттай. Цэврүүнүүд хагарч шүүс татсан байдалтай.

**1. Дээрхи тохиолдолд ямар дерматитыг таамаглах вэ?**

A. Хордлого харшлын
B. Хавьтал харшлын
C. Энгийн хавьтлын
D. Дюрингийн
E. Атопийн

**2. Жинхэнэ полиморфизм гэж юу вэ?**

A. Нэг зэрэг олон анхдагч болон хоёрдогч тууралт гарах
B. Нэг зэрэг олон хоёрдогч тууралт бий болох
C. Нэг зэрэг олон анхдагч тууралтууд гарах
D. Хавьтал харшлын дерматитын үед гарна
E. Энгийн хавьтлын дерматитын үед гарна

**3. Дээрхи өвчин дархлааны аль урвалаар явагдах вэ?**

A. Хэт мэдрэгшлийн хурдан урвалаар
B. Эс хордуулах урвалаар
C. Дархан бүрдлийн урвалаар
D. Хэт мэдрэгшлийн аажим урвалаар
E. Алинаар нь ч явагдаж болно

**4. Дээрхи өвчний үед хийгдэх ерөнхий эмчилгээг сонгон уу?**

1. Пенициллин
2. Кортикостироид
3. Ацикловир
4. Лоратадин
5. Флюконазол

**5. Өвчтөнд өгөх зөвлөгөөг сонгоно уу?**

1. Эмчилгээний дараа наалтыг үргэлжлүүлэн хэрэглэх

2. Энэ наалтыг дахин хэзээ ч  хэрэглэхгүй байх
3. Биеийн дархлаанаас хамаарч наалт дахин дерматит өгч болно, өгөхгүй ч байж болно.
4. Наалтын төрлийг сольж хэрэглэх
5. Наалт хэрэглэснээс амь насанд аюултай байдалд хүрч болно.

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| B | C | D | C | C |

**Тохиолдол 6**

Өвчтөн М., 35 настай, эмэгтэй

**Зовиур:** Хацар, хамрын арьс улайсан, хуурайшсан. Халууцах, нар салхинд явсны дараа бага зэрэг хорсож загатнана.

**Anamnesis morbi:** 1 сарын өмнө зугаалганд яваад ирсний дараа хацрын арьс улайж хуурайшиж эхэлсэн. Гойд загатнах, өвдөх зовиургүй боловч  нар салхинд явах, халууцах үед улайлт нэмэгдэнэ.

**Anamnesis vitae:** Ам бүл 6. Одоогоор ажил хийдэггүй. Бөөр болон үе мөч өвддөг шалтгаанаар эмнэлэгт хэд хэдэн удаа хэвтэж байсан боловч тодорхой оношийг мэдэхгүй.

**Status preacens obj:** Биеийн ерөнхий байдал дунд зэрэг, ухаан саруул, байрлал идэвхитэй. Арьсны өнгө ердийн, арьсан доорх өөхөн эдийн хөгжил дунд зэрэг, арьсны зурчлаа улаан. Гарын хуруунуудын үе хавдсан, хөндүүр.

**Status localis:** 2 хацрын товгор, хамрын арьсан дээр  хавагнасан**,** улайсан толбон тууралттай. Голомтын төвд нягт суусан цайвар хайрстай байв.

**1. Дээрх тохиолдолд та ямар өвчнийг таамаглах вэ?**

A. Хайрст үлд
B. Улаан чонон яр
C. Ягаан батга
D. Хажираст экзем
E. Арьсны  хяргагч үлд

**2. Онош тодруулахын тулд дараах эмнэл зүйн шинжийг сонгоно уу?**

A. Никольскийн шинж
B. Аушпицийн шинж
C. Асбо Хансены шинж
D. Бенье Мещерскийн шинж
E. Керион Цельсийн шинж

**3. Оношоо батлахын тулд та ямар шинжилгээ хийх вэ?**

1. Аврага эс илрүүлэх
2. Бөөмийн эсрэг эсрэг бие илрүүлэх
3. Хайрсыг микроскопт шинжлэх
4. LE эс илрүүлэх
5. Дархан туяарлын шинжилгээ

**4. Та уг өвчнийг эмчлэхдээ ямар зарчмыг баримтлах вэ?**

1. Нар салхи, галаас хол байх
2. Бусад нянгийн голомтот өвчнийг эмчлэх
3. Дотор эрхтэнийг шинжилж үзэх
4. Хумхайн эсрэг эм хэрэглэх
5. Дархлаа дарангуйлахэм уулгах

**5. Делагил нь:**

1. Хумхайн эсрэг үйлчилгээтэй
2. Гэрэлд мэдрэг өвчнүүдийн үед хэрэглэдэг
3. Хинолины бүлэгт хамаардаг
4. Дархлаа дарангуйлах үйлчилгээтэй

5. Цохилтын тунгаар хэрэглэдэг

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| B | D | C | E | A |

**Тохиолдол 7**
Өвчтөн Н, 13 настай, эрэгтэй
**Зовиур:** биеэр тууралт гарна, бага зэрэг загатнана.
**Anamnesis morbi:** 14 хоногийн өмнөөс биеэр тууралт гарч эхэлсэн. Урд нь энэ өвчнөөр 2 удаа эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байсан. Хэд хоногийн өмнө ханиад хүрж, хоолой өвдсөн, эмчилгээ хийлгээгүй.
**Anamnesis vitae:** хоолой ер нь байнга өвддөг. Ямар нэг харшилдаг эм, хоол хүнсний зүйл байхгүй. Удамд нь ийм өвчтэй хүн байдаг эсэхийг мэдэхгүй.Физикийн сонгонд сурдаг, хичээлийн ачаалал их байгаа.
**Status preasens obj:** биеийн ерөнхий байдал дунд зэрэг, ухаан саруул, байрлал идэвхитэй. Арьсны өнгө ердийн, арьсан доорх өөхөн эдийн хөгжил дунд зэрэг, арьсны зурчлаа улаан. Гүйлсэн булчирхай 2 талдаа улайсан.
**Status localis:** Хэвлий, нуруу, мөчдийн гадна гадаргуу, шилбэ тохойгоор тархмал байрласан дуслан хэлбэрийн гүвдрүүт тууралттай. Гүвдрүү нь мөнгөлөг хайрсаар бүрэн хучигдсан.

**1. Хайрст үлдийн эмнэл зүйн хэлбэрүүдийг сонгоно уу?**
1. Шүүдэст хайрст үлд
2. Улайрал
3. Идээт цэврүүнцэрт
4. Хажираст
5. Нөсөөт

**2. Дээрх тохиолдолд хайрст үлд өвчний эмнэл зүйн ямар үе шат вэ?**
A. Улайралын үе
B. Давших үе
C. Эдгэрэх үе
D. Зогсонги үе
E. Шүүдэст үе

**3. Хайрст үлд өвчний давших үеийн шинжүүдийг сонгоно уу?**
1. Гүвдрүүнүүд хайрсаар бүрэн хучигдсан байна
2. Шинээр гүвдрүүнүүд гарна
3. Гүвдрүүнүүд голоосоо шимэгдсэн байна
4. Кебнерийн хариу урвал эерэг
5. Аушпицийн шинж байхгүй

**4. Онош батлахын тулд та юуг тодорхойлох шаардлагатай вэ?**
1. Анамнез
2. Хайрст үлдийн гурвал шинж
3. Эдийн шинжилгээ
4. Хайрсыг шинжлэх
5. LE эс илрүүлэх

**5. Хайрст үлд өвчний эмчилгээнд юуг хэрэглэхгүй вэ?**
A. Харшил эмзэгшил бууруулах
B. Витамин эмчилгээ
C. Дархлаа дэмжих
D. Физик эмчилгээ
E. Шимэгчийн эсрэг эм

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| A | D | C | A | E |

**Тохиолдол 8**

Өвчтөн И 34 настай, эрэгтэй

**Зовиур:** Биеэр тууралт гарсан, халуу оргино, маш хүчтэй загатнана

**Anamnesis morbi:** 2 хоногийн өмнөөс цээж, нуруугаар улаан тууралт гарсан, заримдаа хоорондоо нийлж том зураглал үүсгэнэ, 2-3 цагийн дараа алга болоод орой дахин гарч байсан. Эмчилгээ хийлгээгүй.

**Anamnesis vitae:** Ам бүл 5, дасгалжуулагч

**Status preacens obj:** Биеийн ерөнхий байдал дунд зэрэг, ухаан саруул, байрлал идэвхитэй. Арьсны өнгө ердийн, арьсан доорх өөхөн эдийн хөгжил дунд зэрэг, арьсны зурчлаа улаан.

**Status localis:** Цээж, хэвлий, нуруугаарянз бүрийн хэмжээтэй, зарим хэсгээр өөр хоорондоо нийлсэн, улаан өнгөтэй бэлцрүүт тууралт гарсан байв.

**1. Дээрхи тохиолдолд ямар өвчнийг таамаглаж болох вэ?**

A. Чонон хөрвөс
B. Атопийн дерматит
C. Хавьтал харшлын дерматит
D. Маажуур
E. Хайрст үлд

**2. Бэлцрүүт тууралт үүсэх замыг сонгоно уу?**

1. Эсийн хэт ургалтаас
2. Хөхлөг давхрагын хэт ургалтаас
3. Эс хоорондын холбоос тасарснаас
4. Судасны нэвчимтгий чанар ихсэж хөхлөг давхрагад хаван үүссэнээс
5. Эсийн нэвчдэс бий болсноос

**3. Квинкийн хавангийн үед гарч болох хүндрэлийг хэлнэ үү?**

1. Амьсгал боогдох
2. Ухаан алдах
3. Гэдэсний түгжрэл үүсэх
4. Мэдрлийн үрэвсэл
5. Дүлийрэх

**4. Дээрхи тохиолдолд ямар өвчнүүдээс ялган оношлох вэ?**

1. Тунгалагын судасны зогсонгишил
2. Олон хэлбэрт шүүдэст улайрал
3. Лаиммын боррелиоз
4. Цэврүүт пемфигоид
5. Эритема

**5. Дээрхи өвчний үеийн лабораторийн өөрчлөлтийг сонгоно уу?**

1. Цитологийн шинжилгээ
2. Иммуноглобулин Е тодорхойлох
3. Дархан туяарлын шинжилгээ
4. Захын цусанд эозинофилл тодорхойлох
5. Молекул-биологийн шинжилгээ

| **1** | **2** | **3** | **4** | **5** |
|---|---|---|---|---|
| **A** | **D** | **A** | **E** | **C** |

**Тохиолдол 9**

Өвчтөн О 12 настай, эмэгтэй

**Зовиур:** Хүзүүний 2 тал, тохой, тахимд тууралт гарсан, халуу оргино, маш хүчтэй загатнана

**Anamnesis morbi:** 2 настайгаасаа энэ өвчнөөр өвдөж байгаа, хоолны дэглэм алдах, ядрах үед тууралт гардаг. Арьс их хуурайшдаг. Энэ өвчний улмаас 2 удаа эмнэлэгт хэвтэж байсан.

**Anamnesis vitae:** Аав, ээж, дүүгийн хамт амьдардаг. 7-р ангид суралцдаг. Багадаа салхин цэцэг, улаан бурхан өвчнөөр өвдөж байсан.

**Status preacens obj:** Биеийн ерөнхий байдал дунд зэрэг, ухаан саруул, байрлал идэвхитэй. Арьсны өнгө бараан, маш хуурай, арьсан доорх өөхөн эдийн хөгжил бага, арьсны зурчлаа цагаан.

**Status localis:** Хүзүүний 2 тал, тохойны хонхор, тахимд гүвдрүүт тууралт гарсан, ширшил үүссэн. Маажсаны ормоор зулгархай үүссэн, арьс хуурайшиж уян чанар нь буусан байдалтай байв.

**1. Дээрхи тохиолдолд ямар өвчнийг таамаглаж болох вэ?**

A. Чонон хөрвөс
B. Атопийн дерматит
C. Хавьтал харшлын дерматит
D. Маажуур
E. Хайрст үлд

**2. Ширшил өвчний тодорхойлолтыг заана уу?**

1. Өнгөн хөрс гуужсаны дүнд үүснэ
2. Маажсаны улмаас үүснэ
3. Цэврүү хагарсаны дараа үүснэ
4. Гүвдрүүнүүд нийлсэний дүнд үүснэ
5. Тав унасны дараа үүснэ

**3. Атопийн дерматитын эмнэл зүйн ангилалыг хэлнэ үү?**

1. Шүүдэст хэлбэр
2. Улайралт-гуужилт
3. Улайралт-хайрсжилт
4. Прурито
5. Зангилаат

**4. Ямар өвчнүүдийн үед цусанд иммуноглобулин Е ихсэж болох вэ?**

1. Дюрингийн дерматит
2. Чонон хөрвөс
3. Хавьтал-харшлын дерматит
4. Атопийн дерматит
5. Энгийн дерматит

**5. Туяа эмчилгээг дараах өвчнүүдийн үед хийж болно.**

1. Арьс цайх өвчин
2. Атопийн дерматит
3. Хайрст үлд
4. Стивенсон-Джонсоны хам шинж
5. Лайлын хам шинж

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| B | C | B | C | A |

**Тохиолдол 10**

Өвчтөн Ү 45 настай, эмэгтэй

**Зовиур:** Өвчтан халуурна, биеэр тууралт гарсан, өвдөнө, бие сульдана, толгой өвдөнө гэсэн зовиуртай эмчид үзүүлсэн.

**Anamnesis morbi:** 2 хоногийн өмнөөс халуурч эхэлсэн. Биеэр юм гарч, шалбарсан. Эмэгтэйчүүдийн өвчний улмаас эмчилгээ хийлгээд хэд хонож байна.
**Anamnesis vitae:** Ам бүл 4. Үсчин. Эм тарианд урд өмнө харшилж байгаагүй.
**Status preacens obj:** Өвчтөний биеийн байдал хүндэвтэр, шаналсан царайтай, асуултанд удаан хариулна. Биеийн халуун 39 хэм. Нүд, амны салст эмзэглэлтэй.
**Status localis:** Их бие, мөчдөөр тархмал толбо, том цэврүү гарч шалбархай харагдана. Асбо Хансены шинж, Никольскийн шинж эерэг илэрнэ.

**1. Таны тавих урьдчилсан онош ба эхний авах арга хэмжээ?**

A. Хавьтал харшлын дерматит + харшилж буй аллергенийг илрүүлж зогсоох, антигистамины бэлдмэл өгөх
B. Стивенс Джонсоны хам шинж + харшилж буй эмийг зогсоох яаралтай эмчилгээг эхлэх
C. Хордлого харшлын дерматит + харшилж буй эмийг зогсоох яаралтай эмчилгээг эхлэх
D. Цэврүүтэх өвчин + яаралтай хэвтүүлж эмчилгээг эхлэх
E. Лайеллын хам шинж + харшилж буй эмийг зогсоох, яаралтай эмчилгээг эхлэх

**2-5. Дараах асуултуудад тохирох хариултыг уялдуулан сонгоно уу?**

**2.Никольскийн 1-р шинж нь**
**3.Никольскийн 2-р шинж нь**
**4.Никольскийн 3-р шинж нь**
**5.Асбо Хансений шинж нь**

A. Цэврүүний голд дарахад эрүүл арьс руу тэлж томорно
B. Хагарсан цэврүүний салбархайнаас татахад арьс нь эрүүл хэсэг рүү хуурна
C. Цэврүүнээс хол байгаа эрүүл арьсыг үрэхэд арьс нь ховхорно
D. Ойрхон байрласан хоёр цэврүүний хоорондох эрүүл арьсыг үрэхэд арьс нь ховхорно

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| E | B | D | C | A |

**<u>Сорил-2</u>**

1.2.3 – зөв бол A
1.2.3.4 – зөв бол B
2.4 – зөв бол C
4 – зөв бол D
Бүгд зөв бол E

1. Жинхэнэ арьсны бүтцийн хэсгүүд ?
   1. Арьсны дайврууд
   2. Цусны судас
   3. Мэдрэлийн төгсгөл
   4. Кератиноцит
   5.Лангергансийн эс
2. Арьсан дахь сэртэнт эсүүд ?
   1. Лангергансын эс
   2. Меркелийн эс
   3. Меланоцит
   4. Лимфоцит
   5. Фибробласт

3. Арьсны өнгөн хөрсний уураг ?
    1. Кератогиалин
    2. Элейдин
    3. Филлагрин
    4. Кератин
    5. Профилаггрин

4. Үсний ургалтын хамгийн урт үргэлжилдэг фазыг дурдана уу?
    1. Катаген
    2. Телоген
    3. Анафаз
    4. Анаген
    5. Телефаз
5. Арьсны эвэршлийн үйл ажиллагаа аль давхраас эхлэх вэ?
    1. Эвэрлэг
    2. Үрлэг
    3. Өргөст
    4. Суурийн
    5. Тунгалаг
6. Аль туяа нь өнгөн хөрсөнд шингэх вэ?
    1. 500 – 600 нм
    2. 400 – 500 нм
    3. 320 – 400 нм
    4. 290 – 320 нм
    5. 200 – 290 нм
7. Арьсны сэртэнт эсүүд дараах үүрэг гүйцэтгэдэг.
    1. Дархлалын
    2. Мэдрэхүйн
    3. Нөсөө нийлэгжүүлэх
    4. Эрдэсийн солилцооны
    5. Дулаан зохицуулах
8. Арьсны бүтцийн дараах хэсгүүд нь дархлалын үүрэг гүйцэтгэнэ.
    1. Кератиноцит
    2. Лангергансийн эс
    3. Лимфоцит
    4. Тарган эс
    5. Гистоцит
9. Арьсанд оршин, халуун, хүйтний мэдрэхүйн төгсгөлийг дурдана уу?
    1. Меркелийн эс
    2. Колбо Краузе
    3. Фатер Пачины биенцэр
    4. Руффины биенцэр
    5. Мейснерийн биенцэр
10. Арьсны гадаргуугийн тослог ихтэй байршлыг дурдана уу ?
    1. Дээд мөч
    2. Доод мөч
    3. Цээжний өмнө хэсэг
    4. Хуйх
    5. Далны орчим
11. Арьс дулаан алдалтыг дараах байдлаар зохицуулдаг.
    1. Дамжуулах
    2. Цацаргах
    3. Ууршуулах
    4. Энергийн нөөц болох
    5. Өвөрмөц рецептор цочрох

12.Үсний тархилаг бодисыг ямар үсэнд хамгийн сайн тодорхойлж болох вэ?
1. Богино
2. Зөөлөн
3. Шар
4. Урт
5. Ширүүн

13. Үс унаад дахин ургах хугацааг тодорхойлно уу?
1. 10 – 14 сар
2. 90 – 110 хоног
3. 2 жил
4. 4 жил
5. 6 жил

14. Хоёрдогч тууралтад аль нь хамаарах вэ?
1.Хайрс
2. Ургацаг
3. Зулгархай
4. Шалбархай
5.Сорви

15. Тав үүсгэдэг анхдагч тууралтууд ?
1. Цэврүү
2. Цэврүүнцэр
3. Идээт цэврүү
4. Гүвдрүү
5. Бэлцрүү

16. Фликтен дараах шинжийг агуулна.
1. Улбагар
2. Амархан хагардаг
3. Нимгэн бүрхүүлтэй
4. Зах руугаа тэлэх хандлагатай
5. Шингэн шаргал агуулагдахуунтай

17. Том цэврүү хагарахад ямар хоёрдогч тууралт үүсэх вэ?
1. Шарх
2. Ургацаг
3. Цууралт.
4. Шалбархай
5. Хайрс

18. Сорви үүсгэн эдгэрдэг анхдагч тууралт ?
1. Гүвдрүү
2. Товруу
3. Цусархаг толбо
4. Зангилаа
5. Бэлцрүү

19. Аль нь арьсны гүнд хүрч үйлчлэх вэ?
1. Шавшлага
2. Цацлага
3. Зайлмаг
4. Тос
5. Өтгөн тос

20. Даврын түрхлэгийн арьсанд илрэх гаж нөлөө юу вэ?
1. Арьс хатингарших
2. Нөсөөжилт ихсэх
3. Үсжих
4. Батга гарах
5. Үхжил үүсэх

21. Арьсны өвчний үед хэсэг газрын эмчилгээг хийхэд юуг анхаарах вэ?

1. Тууралтын тоо
2. Голомтын байрлал
3. Тууралтын өнгө
4. Голомтын шинж чанар
5. Ерөнхий биеийн байдал

22. Хамуу өвчин яаж халддаг вэ?
1. Аяга, таваг
2. Нягт хүрэлцэх
3. Нийтийн халуун усны газар
4. Халдварлагдсан хувцас, цагаан хэрэгсэл
5. Цэцэрлэг, сургууль

23. Хамуу өвчний гүвдрүү ямар онцлогтой вэ?
1. Шүүстэнэ
2. Хосоор байрлана
3. Байнга загатнана
4. Цусархаг тав тогтоно
5. Сорвижиж эдгэрнэ

24. Хамуу өвчнөөс урьдчилан сэргийлэхийн тулд ямар арга хэмжээ авах вэ?
1. Урьдчилан сэргийлэх үзлэг хийх
2. Илэрсэн өвчтөнг хугацаанд нь төгс эмчлэх
3. Голомтонд төгс ариутгал хийх
4. Хувь хүний ариун цэврийг сайжруулах
5. Эрүүл мэндийн боловсрол олгох

25. Хамуу өвчний хүндрэл ?
1. Хавьтал харшлын дерматит
2. Идээт өвчин
3. Нейродермит
4. Экземших
5. Энгийн хавьтлын дерматит

26. Хамуу өвчнийг эмчлэхэд алийг нь сонгох вэ?
1. Ung.Clotridenk
2. Ung.Benzylbenzoat
3. Ung. Salicilicy
4. Ung. Sulfurici
5. Ung. Zincy oxydaty

27. Толгойн бөөсийг эмчлэх Педиллин шампунийг ямар үсэнд хэрэглэх вэ?
1. Хуурай үсэнд
2. Химитэй үсэнд
3. Урт үсэнд
4. Нойтон үсэнд
5. Богино үсэнд

28. Олон өнгөт үлд өвчнийг оношлох аргууд ?
1. Вудийн гэрэл
2. Бальцерийн сорил
3. КОН сорил
4. Аварга эс илрүүлэх
5. Арьсны дуран

29. Олон өнгөт үлд өвчний туурал зонхилон хаана байрлах вэ ?
1. Мөчдөөр
2. Тавхай
3. Алга
4. Их бие
5. Нүүр

30. Ямар өвчний үед усанд орохыг хориглодог вэ?
1. Хавтгай улаан үлд

2. Арьсны мөөгөнцөр
3. Хамуу
4. Ягаан үлд
5. Хайрст үлд

31. Ягаан үлд өвчний үед эмнэл зүйн шинж илрэх вэ?
    1. Үрчгэр тамхины цаасны шинж
    2. Медальоны шинж
    3. Эх толбо
    4. Охин толбо
    5. Зулгархай

32. Хуйханд байрласан, өвчин эмзэглэлтэй, шахахад үсний хүүдий бүрээс идээ гарахыг ямар шинж гэх вэ?
    1. Өвчтөн халуурсан
    2. Нэвчдэст суурь
    3. Голомтонд үс сугарсан
    4. Керион Цельсийн шинж
    5. Голомтонд хугарсан үстэй

33. Арьсны үлдийн үед авах арга хэмжээ ?
    1. Нянгийн эсрэг эмчилгээ
    2. Дархлаа дэмжих
    3. Үрэвслийн эсрэг эмчилгээ
    4. Мөөгөнцрийн эсрэг түрхлэг
    5. Үрэвсэлийн эсрэг түрхлэг

34. Идээт нэвчдэст үлдийн халдварын эх уурхай нь юу вэ?
    1. Халдвартай хүн
    2. Халдварлагдсан сам
    3. Халдвартай малгай
    4. Цахлаатай тугал
    5. Дотуур байр

35. Нүүрэнд голомт нь байрладаг арьсны өвчнийг нэрлэнэ үү?
    1. Нарны экзем
    2. Хүүхдийн экзем
    3. Зээрэнцэг  маягийн улаан чонон яр
    4. Өнгөц түүхий
    5. Энгийн герпес

36. Олон төрлийн тууралтаар илэрдэг өвчнийг сонгоно уу?
    1. Герпес
    2. Үлд
    3. Түүхий
    4. Хавьтал харшилын дерматит
    5. Хатиг

37. Зээрэнцэг маягийн улаан чонон яр өвчний үед дараах зөвөлгөөг өгнө.
    1. Нарнаас хамгаалах тос тогтмол хэрэглэх
    2. Нарны шил зүүх
    3. Саравчтай малгай өмсөх
    4. Гадаа ажиллахаас татгалзах
    5. Угаалгын нунтаг хэрэглэхгүй байх

38. Стафилококкийн шалтгаант арьсны өвчин үүсэхэд дараах хүчин зүйл нөлөөлнө.
    1. Арьсны бүрэн бүтэн байдал алдагдах
    2. Таргалалт
    3. хөлрөлт
    4. Дархлалын үйл ажиллагаа алдагдах
    5. Арьсны бохирдол

39. Чонон хөрвөс өвчний үед тууралт хаагуур гарах вэ ?

1. Харшил авсан газраар
2. Нүүрээр
3. Их биеэр
4. Хаа ч хамаагүй
5. Биеийн ил хэсгээр

40. Маажуур өвчин нь:
    1. Улирлын шинжтэй
    2. Архаг удаан явцтай
    3. Нүдний салст, уруулын улаан хэсгийн үрэвсэл илэрнэ
    4. Гүвдрүү туурдаг
    5. Биеийн далд хэсэгт тууралт гардаггүй

41. Витилиго өвчин нь:
    1. Толбо нь хатингаршилт, гуужилттай
    2. Сүүн цагаан өнгөтэй толбон тууралтаар илэрнэ
    3. Загатнаа байхгүй
    4. Арьсны архаг эмгэг
    5. Толбо үүссэн хэсгийн үс нь хугарч гэмтэнэ

42. Моллюскийн эмчилгээнд дараах аргыг хэрэглэнэ
    1. Саллицилын спиртээр арчих
    2. Электрокоагуляци хийх
    3. Тэжээлийн тос түрхэх
    4. Зориултын чимхүүрээр авч, иод түрхэх
    5. Зовиракс түрхэх

43. Хуйханд идээт, хурц үрэвсэлт голомт гарсан бол та ямар өвчний тухай бодох вэ?
    1. Мундас
    2. Буглаа
    3. Хуйхны идээт нэвчдэст хяргагч үлд
    4. Хатиг
    5. Түүхий

44. Атопийн дерматит үүсэхэд нөлөөлөх хүчин зүйл
    1. Эхийн жирэмсэн үеийн хооллолт
    2. Жирэмсний хожуу хордлого
    3. Хүүхдийн хооллолт
    4. Агаарын  бохирдолт
    5. Хүйтний улирал

45. Хавтгай үү биеийг аль хэсэгт гарах дуртай вэ?
    1. Гар
    2. Алга
    3. Бэлэг эрхтэн
    4. Нүүр
    5. Хаана ч хамаагүй

46. Десмоглейн 1 ба 3 өвчтөний ийлдсэнд эерэг илэрч байвал та ямар өвчний тухай бодох вэ?
    1. Цэврүүт пемфигойд
    2. Дюрингийн дерматит
    3. Цэврүүт  түүхий
    4. Жинхэнэ цэврүүтэх өвчин
    5. Тэмбүүгийн цэврүүдэлт

47. Асбо-Хансены шинж тохирох хариултыг олно уу.
    1. Хагарсан цэврүүний салбархайнаас татахад эрүүл арьс хуурна
    2. 2  цэврүүний хооронд эрүүл арьсыг үрэхэд арьс хуулрах
    3. Цэврүүнээс хол эрүүл арьсыг үрэхэд арьс хуурах
    4. Цэврүүний голд дарахад цэврүү томорно
    5. Цэврүүнүүд өөр хоорондоо нийлж томрох

48. Лайеллийн хам шинжийн үед ямар эмийг яаралтай хэрэглэх вэ?

1. Антибиотик
2. Сульфаниламид
3. Витамин
4. Кортикостероид
5. Крем

49. Бензилпероксид нь дараах үйлчилгээг үзүүлнэ:
    1. Тосон бөглөөг арилгана
    2. Тосон бөглөө үүсэхээс урьдчилан сэргийлнэ
    3. Андроген даавруг багасгана
    4. Анаэроб бактерийг устгана
    5. Тосны ялгаралтыг багасгана
50. Апокрин хөлсний булчирхай хаана байрлах вэ?
    1. Суга
    2. Хөхний толгойн орчим
    3. Хүйс тойроод
    4. Бэлэг эрхтэн
    5. Шулуун гэдэсний амсар тойрч
51. Энгийн үү ямар замаар дамжиж болох вэ?
    1. Өөрөө өөрөөсөө
    2. Шууд
    3. Шүлсээр
    4. Шууд бус
    5. Бэлгийн замаар
52. Халдварт нялаахай өвчний тууралтын онцлог нь:
    1. Цагаан эсвэл биений өнгөтэй гүвдрүүн тууралт
    2. Зөв дугуй, бөмбөлөг хэлбэртэй
    3. Гүвдрүү нь ээдэм маягийн агууламжтай
    4. Тууралт нь өвдөлт, зовиургүй
    5. Гүвдрүү нь төвдөө хонхорхойтой
53. Арьс арчилгааны үндсэн зарим
    1. Цэвэрлэх
    2. Хамгаалах
    3. Чийгшүүлэх, тэжээл өгөх
    4. Баг тавих
    5. Гоо сайхны үйлчилгээ хийлгэх
54. Олон хэлбэрт шүүдэс улайрал авчний тууралт биеийн аль хэсэгт гарах вэ?
    1. Нүүр
    2. Дээд мөчдийн төгсгөл
    3. Их бие
    4. Доод мөчдийн төгсгөл
    5. Хуйх
55. Толгойн бөөсөнд 10-20% бензилбензоатын цийдмэг түрхэж, боогоод хэдэн минутын дараа угаах вэ?
    1. 10 мин
    2. 20 мин
    3. 30мин
    4. 40 мин
    5. 50 мин
56. Арьсны өнгөц үлд дараах эмнэлзүйн шинжээр илэрнэ.
    1. Голомт нүүр, хүзүү, бугалга, их биеэр гарна
    2. Үл мэдэг загатнана
    3. Толбо нь зөв дугуй хэлбэртэй, зах руугаа тэлж томроно
    4. Бага зэрэг халуурна
    5. Хумс гэмтэнэ
57. Хуйхны өнгөц үлд дараах эмнэлзүйн шинжээр илэрнэ.

1. Үс хугарна (1–2 мм)
2. Хурц бус үрэвслийн толбо
3. Голомтод хайрс үүснэ
4. Үс сугарч унана
5. Улайж, хавдана

58. Хуйхны идээт нэвчдэст хяргагч үлдийн эмнэлзүйн шинжийг нэрлэ.
1. Зөгийн үүрийн шинж
2. Өвдөнө
3. Идээт нэвчдэст голомт үүсэх
4. Голомтын үс унах
5. Халуурах

59. Тавхайн үлд хаанаас халдах боломжтой вэ?
1. Нийтийн халуун усны газар
2. Саун
3. Бассейн
4. Үсчин
5. Гоо сайхан

60. Тавхайн үлдийн эмнэл зүйн шинж ?
1. Цэврүүнцэр үүсэх
2. Хөлийн ул бага зэрэг улайж гуужих
3. Хөлийн хурууны салаагаар зулгархай, шалбархай үүсэх
4. Загатнах
5. Өвдөх

61. Чонон хөрвөсийн эмнэлзүйн онцлог
1. Өвчин цочмог эхлэх
2. Бэлцрүү туурах
3. Тууралт амархан арилах
4. Загатнах
5. Бөөлжих

62. Мөөгөнцөрт өвчнийг оношлоход дараах шинжилгээ хийнэ.
1. Үзлэг хийх
2. КОН  сорил
3. Голомтыг дурандах
4. Сабурогийн тэжээлт орчинд өсгөвөрлөх
5. Бальцерийн сорил тавих

63. Арьсны үлдийн цөөн голомтонд дараах эмчилгээг хийнэ.
1. Гризеофульвин
2. T-rae iodi 2-5%
3. Нистатин
4. Ung. Clotrimazole 1%
5. Низорал

64. Улны эпидермофитийн гэмтэл хөлийн аль хуруунаас эхлэх вэ?
1. Долоовор
2. Чигчий
3. Эрхий
4. Ядам
5. Дунд

65. Мөөгөнцрийн эсрэг үйлчилгээтэй антибиотик
1. Низорал
2. Ламизил
3. Фунголон
4. Нистатин
5. Леворин

66. Арьсны гадаргууд ямар ямар идээлүүлэгч нян оршдог вэ?
1. Кандида алебиканс

2. Стафиллококк
3. Микобактери
4. Стрептококк
5. Пневмококк

67. Энгийн хавьтлын дерматит нь
1. Нөхцөлт цочруулаар үүснэ
2. Цочруулын хүчээс эмнэлзүй шинж хамаарна
3. Цочруул үйлчилсэн хэсэгт өөрчлөлт үүснэ
4. Нөхцөлт бус цочруулаар үүснэ
5. Голомтын хэмжээ том байна.

68. Өнгөц түүхийгээр зонхилон хэн өвчлөх вэ?
1. Насанд хүрэгчид
2. Хүүхэд
3. Эрэгтэйчүүд
4. Эмэгтэйчүүд
5. Настан

69. Гидроаденит гэж юу вэ?
1. Үсний уутны идээт үрэвсэл
2. Хөлсний булчирхайн идээт үрэвсэл
3. Тосны булчирхайн идээт үрэвсэл
4. Апокрин хөлсний булчирхайн идээт үрэвсэл
5. Стрептококкийг шалтгаантай арьсны идээт өвчин

70. Бүслүүр үлдийн үүсгэгчийг нэрлэнэ үү?
1. Энгийн герпес вирус – 1
2. Эпстейн Барр вирус
3. Энгийн герпес вирус – 2
4. Варицелла зостер вирус
5. Цитомегаловирус

71. Ямар ямар төрлийн үү байдаг вэ?
1. Хавтгай
2. Ердийн
3. Алга улны
4. Шовх
5. Бэлгийн үү

72. Халдварт моллюск өвчний үед ямар тууралт гарах вэ?
1. Цэврүү
2. Товруу
3. Толбо
4. Гүвдрүү
5. Зангилаа

73. Бүслүүр үлд дараах шалтгаантай арьсны өвчин юм.
1. Харшил эмзэгшил
2. Халдвар
3. Нян
4. Вирус
5. Олон шалтгаант

74. Энгийн герпесийн үед дараах онцлогтой тууралт гарна.
1. Цэврүү
2. Ганц нэг цэврүүнцэр
3. Бүлгээрээ байрласан гүвдрүү
4. Бүлгээрээ байрласан цэврүүнцэр
5. Бага зэрэг ирвэгнэх зовиур

75. Энгийн герпесийн үед хийх цитологийн шинжилгээнд юу илрэх вэ?
1. Цайвар трепонем
2. Тцанкийн эс

3. Эозинофил
4. Аварга эс
5. Нейтрофил

76. Өнгөц түүхийн голомт зонхилон хаана байрлах вэ?
1. Хуйх
2. Мөчдөөр
3. Өвдөг, тохой
4. Нүүр
5. Алга, ул

77. Герпесийн халдварын үед цитологийн шинжилгээнд авах дээж?
1. Идээ
2. Тав
3. Хайрс
4. Цэврүүний шингэн
5. Цус

78. Үү өвчнөөр аль насны хүмүүс өвчлөх вэ?
1. Хүүхэд
2. Залуучууд
3. Настай хүмүүс
4. Аль ч насныхан
5. Настайчууд

79. Хоол хүнснээс болж үүссэн дерматитийн үед аль эмчилгээ зохимжтой вэ?
1. Антибиотик
2. Банк тавих
3. Цус солих
4. Хоол боловсруулах замыг цэвэрлэх
5. Витамин уулгах

80. Нөхцөлт бус цочруул гэдэг нь?
1. Мэдрэг арьсанд дерматит үүсгэдэг цочруул
2. Маш хүчтэй цочруул
3. Сул хүчтэй цочруул
4. Ямарч хүнд дерматит үүсгэх цочруул
5. Арьсанд үхжил үүсгэдэг цочруул

81. Хордлого харшлын дерматитийн хүнд хэлбэр
1. Стивенсона Джонсоны хам шинж
2. Хоёрдогч эритродермии
3. Цэврүүтэх өвчин
4. Лайеллын хамшинж
5. Тархмал герпес

82. Дерматитийн үед ямар тууралт гарч болох вэ?
1. Толбо
2. Гүвдрүү
3. Цэврүү
4. Цэврүүнцэр
5. Товруу

83. Энгийн дерматитын эмнэлзүй цочроогч хүчин зүйлийн юунаас хамаарах вэ?
1 Тухайн зүйлд арьс хэт мэдрэгжсэн байх
2. Үйлчилж буй хүчин зүйлийн үйлчилсэн хугацаа
3. Цочруулын эзэлсэн талбай
4 Цочруулын үйлчилсэн хүч
5. Цочруулын физик химийн шинж чанар

84. Хавьтал харшлын дерматитын онцлог юу вэ?
1. Нөхцөлт цочруул нөлөөлснөөс үүснэ
2. Голомт нь үйлчилсэн цочруулын талбайнаас их байна
3. Үхжил илрэхгүй

4. Уг хүчин зүйл давтан нөлөөлснөөс хамаарна
5. Загатнах, хорсох

85.Цочмог экзем өвчний эмнэл зүйг анх хэн гэдэг эрдэмтэн тайлбарласан вэ?

1. Кейбнер
2. Ауспиц
3. Уикхем
4. Крейбех
5. Жибер

86. Мэргэжлийн экземийн онцлог шинж тэмдгийг заана уу?

1. Ширшил болон цууралт ихтэй
2. Ажил хийж буй үед сэдэрнэ
3. Хайрст тавтай
4. Гараар гарна
5. Архаг явцтай

87. Атопийн дерматитийн оношлогооны үндсэн шалгуур?

1. Архаг дахилтат явц
2. Голомт тодорхой байрлалтай байх
3. Гэр бүлийн харшлын өгүүлэл
4. Загатнах
5. Халуурах

88. Атопийн дерматитийн оношлогооны туслах шалгуур?

1. Арьс хуурайших
2. Арьсны халдварт өртөмхий байх
3. Нүд тойрсон нөсөөжилт
4. Өвчин бага насанд эхлэх
5. Ийлдсэнд IgE ихсэх

89. Зээрэнцэг маягийн улаан чонон яр өвчний үед ямар тууралт гарах вэ?

1. Улайрал
2. Хайрс
3. Хатингаршил
4. Бэлцрүү
5. Сорви

90.Бенье Мещерскийн шинж гэж юу вэ?

1. Хайрс нь нягт суугдсан байна
2. Хайрс нь амархан ховхорч унана
3. Хайрс нь тосны уут руу шигдэж орсон байна
4. Хайрсыг хуулахад хөндүүр өвчтэй байна
5. Хайрс хуулахад гадаргуу нь нойтон байна

91.Дараах шинж нь цэврүүтэх өвчнийг оношлох шинж?

1. Мантугийн сорил
2. Кебнерийн шинж
3. Иодын сорил
4. Никольскийн шинж
5. Ауспицийн шинж

92.Кортикостероид эмийг заавал хэрэглэх өвчин аль нь вэ?

1. Идээт өвчин
2. Хатигшил
3. Хайрст үлд
4. Энгийн цэврүүтэх өвчин
5. Тархмал хэлбэрийн энгийн герпес

93. Жинхэнэ цэврүүтэх өвчний үед илрэх тууралтыг нэрлэнэ үү?

1. Цэврүүнцэр
2. Идээт цэврүү
3. Эритема
4. Цэврүү

5. Бэлцрүү

94. Никольскийн шинж дараах өвчний үед илэрнэ.
1. Дюрингийн дщрматит
2. Цэврүүт герпес
3. Цэврүүт түүхий
4. Цэврүүтэх өвчин
5. Пемфигойд

95. Дюрингийн дерматит гэж оношлох үндэслэл
1. Архаг дахилтат явцтай
2. Загатнаа ихтэй
3. Арьсан дээр олон төрлийн тууралт гардаг
4. Зөвхөн 4 мөчөөр тууралт гардаг
5. Ахимаг насны хүмүүс өвчилдөг

96. Цэврүүт бүлэг өвчинд дараах өвчин орно.
1. Цэврүүтэх өвчин
2. Пемфигойд
3. Дюрингийн дерматит
4. Цэврүүт эпидермолиз
5. Цэврүүт түүхий

97. Хавтгай улаан үлд өвчний гүвдрүүний онцлог
1. Хөхөлбөр улаан өнгөтэй
2. Төвдөө хүйс маягийн хонхортой
3. Олон өнцөгт хэлбэртэй
4. Барзгар гадаргуутай
5. Хивгэн хайрстай

98. Хайрст үлдийн гурвал шинжийг дурдана уу?
1. Лааны зоргодсон шинж
2. Төгсгөлийн хальс
3. Цэгэн цус харвалт
4. Поспеловын шинж
5. Зондын цөмрөх шинж

99. Хайрст үлд өвчний үед ямар тууралт гарах вэ?
1. Толбо хайрс
2. Цэврүү тав
3. Гүвдрүү хайрс нөсөөт толбо
4. Гүвдрүү, хайрс
5. Гүвдрүү ширшил

100. Хайрст үлд өвчний гүвдрүү дараах онцлогтой
1. Мөчдийн тэнийлгэгч гадаргуугаар байрлана
2. Хөвсгөр, амархан хусагддаг хайрстай
3. Зах руугаа бага зэрэг томордог
4. Зэсэн улаан өнгөтэй
5. Тэлж томрохгүй

Сорилын түлхүүр-2

1. A
2. A
3. E
4. D
5. D
6. D
7. A
8. E
9. C
10. D
11. A
12. D
13. D
14. E
15. A
16. E
17. D
18. C
19. D
20. A
21. C
22. C
23. C
24. E
25. C
26. C
27. D
28. A
29. D
30. D
31. B
32. D
33. D
34. B
35. E
36. D
37. B
38. E
39. D
40. C
41. C
42. D
43. B
44. E
45. D
46. D
47. D
48. D
49. D
50. E
51. C
52. E
53. A
54. C
55. D
56. A
57. A
58. E
59. A
60. E
61. B
62. C
63. C
64. C
65. B
66. C
67. A
68. C
69. D
70. D
71. E
72. D
73. D
74. D
75. D
76. D
77. D
78. D
79. D
80. D
81. D
82. B
83. C
84. E
85. D
86. C
87. B
88. E
89. A
90. D
91. D
92. D
93. D
94. D
95. A
96. A
97. A
98. A
99. D
100. A